

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/8/СТА-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	11
4.2	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	12
4.3	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.4	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	14
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН "ШОХОЙ ТООСГО
НЭГДЭЛ" ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ,
ХУРАНДАА Б.БАТТУЛГА ТАНАА

2019.03.15 № 06/472
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын "Шохой тоосго нэгдэл" ТӨААТҮГ-ЫН 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын "Шохой тоосго нэгдэл" ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын "Шохой тоосго нэгдэл" ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын "Шохой тоосго нэгдэл" ТӨААТҮГ-ын газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын захирал, хурандаа Б.Баттулга Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дүгээр сарын 15-наас 2019 оны 03 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК-ийн захирал Ч.Мөнхтуяа, чанарын хяналтын менежер А.Оюун, аудитор Э.Цэвээнсүрэн нар хариуцаж хэрэгжүүлэв.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланг “Уваа уул аудит” ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 03/73 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ нь “Дотоодын үйлдвэрийг дэлхийн жишигт хүргэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

ШШГЕГ-ын даргын 1997 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/93 дугаар тушаалаар Мааньт дахь Хорих 415 дугаар ангид ял эдэлж байгаа хоригдлыг ажлын байраар хангах, үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шохойн чулуу олборлох;
- Шохой шатааж шохой гаргах
- Замаска бэлдэц хийх
- Эрдэст нунтаг
- Мозайкан чулуу үйлдвэрлэл явуулах.

2018 онд чулуу олборлох хэсэгт 10 хоригдол, шохойн цехед 24 хоригдол, бутлуурын цехед 6 хоригдол ажиллаж ажлын байраар хангагдсан. 4691 тн шохойн чулуу олборлосон, 1414 тн шохой гаргасан, 575 тн замасканы бэлдэц хийсэн, 484 тн эрдэс нунтаг, 1568 тн мозайкан чулууг тус тус үйлдвэрлэсэн байна.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/194 дугаар “Бодлогын баримт бичиг батлах тухай” тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журам, байгууллагын үйл ажиллагааны онцлогт зарим талаараа нийцээгүй байна. Учир нь “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлдөг, 4-н төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулсан бүтээгдэхүүний өртөг тооцдог үйлдвэрийн газар юм.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Юникус” програм хангамж ашигладаг байна.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод

хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Орлогын тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь байгууллагын зардлын дансад алдаа гарсантай холбоотой юм.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2018 оны Орлогын тайлангийн нийт зардал 270.8 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 2.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэлийн түвшин бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг Б401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн. 4 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож үүнээс 2 асуудлыг аудитын явцад залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/Мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	1,695.50	
3	Албан шаардлага өгсөн	1	70,740.00	
	Дүн	2	72,435.50	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Орлогын данстай холбоотой

“Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын уул уурхайн инженер дэслэгч Л.Батцэнгэлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 10 жилийн хугацаатай өгсөн Улаанбаатар хотод байрлах 70.7 сая төгрөгийн үнэтэй 3 өрөө байрыг ШШГЕГ-аас Урдчилж төлсөн зардал дансанд бүртгүүлж тайлант оны орлого өсгөсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7.”төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх”, 10 дугаар зүйлийн 10.1.11.төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдэл: Дээрх асуудлыг шийдвэрлүүлэх талаар албан шаардлага өгөв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх чухал асуудал гараагүй болно.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/40 дугаартай “2018 оны төсвийн төлөвлөгөө батлах тухай” тушаалаар “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төлөвлөгөөг баталсан Үүнд: Шохойн чулуу 21500 тн, Шохой 1000 тн, Мозайкан чулуу 1300 тн, Эрдэс нунтаг 500 тн, Замасканы бэлдэц 500 тн-ыг үйлдвэрлэж, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 283.8 сая төгрөг, борлуулалтын орлого 423.2 сая төгрөг, дээд байгууллагад төвлөрүүлэх орлогыг 40.0 сая төгрөг, орон тоо 9 байхаар баталсан.

Батлагдсан төсвийн нийт гүйцэтгэл: Шохойн чулуу 4692 тн, Шохой 1414 тн, Мозайкан чулуу 1568 тн, Эрдэс нунтаг 484 тн, Замасканы бэлдэц 575 тн-ыг үйлдвэрлэж, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 203.8 сая төгрөг, дээд байгууллагад төвлөрүүлсэн орлого

41.0 сая төгрөг, борлуулалтын орлого 325.9 сая төгрөг буюу 77 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь 2017 онд “Жи Эм Жэй Транспорт” ХХК-тай 30000 тн шохойн чулуу нийлүүлэх гэрээ байгуулсан тайлант онд үлдэгдэл 16000 тн шохойн чулуу нийлүүлэх байсан боловч тус аж ахуй нэгж нь өр төлбөрөө барагдуулаагүйн улмаас нийлүүлэлтээ зогсоосоноос шалтгаалсан.

2.11. Шилэн дансны мэдээлэл

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn/төв аймаг баян сум шохой тоосго төаатүг цахим хуудсанд шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2018 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг 140 мэдээллийг хуулийн хугацаанд нь байршуулсан байна. Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийг 2018 оны жилийн эцсийн байдлаар хугацаанд нь хэрэгжүүлж ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь ШШГЕГ-ын “Шохой тоосго нэгдэл” ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Бараа материалаас 1,695.5 мянган төгрөгийн өглөг хаасан байна. Энэ нь “Үнэн зөв” “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 7 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017.12.31	2018.12.31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	10,978,423.39	16,547,719.56
1.1.2	Дансны авлага	73,808,059.54	41,215,418.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	4,670,309.10	4,448,932.19
1.1.4	Бусад авлага	56,048,832.98	47,243,832.98
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	78,147,446.57	128,761,229.08
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6,712,400.00	75,657,150.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	230,365,471.58	313,874,281.81
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	222,900,493.08	348,257,718.25
1.2.2	Биет бус хөрөнгө	3,835,025.55	694,885,102.43
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	21,188,416.75	13,923,816.79
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	247,923,935.38	1,057,066,637.47
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	478,289,406.96	1,370,940,919.28
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	153,26,915.66	75,600,815.66
2.1.1.3	Татварын өр	35,001,901.91	13,641,714.87
2.1.1.5	Богино хугацаат өр төлбөр	21,106,485.52	9,692,200.02
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	209,372,303.09	98,934,730.55
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	209,372,303.09	98,934,730.55
2.2	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	463,909,966.01	1,156,313,966.01
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		181,724,011.25
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Тайлант үеийн ашиг		128,961,073.61
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-194,992,862.14	-66,031,788.53
2.3.11	Эздийн өмчийн дүн	268,917,103.87	1,272,006,188.73
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	478,289,406.96	1,370,940,919.28

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	364,163,607.28	325,993,992.68
2	Борлуулалтын өртөг	240,126,099.14	172,668,292.43
3	Нийт ашиг(алдагдал)	124,037,508.14	153,325,700.25
5	Хүүгийн орлого	243,423.23	121,645.45
10	Ерөнхий ба удирдлагын зардал	89,818,506.31	92,000,091.45
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	114,116.25	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	-47,641,850.00	73,658,544.78
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-13,065,308.69	135,105,799.03
19	Орлогын татварын зардал	24,342.32	6,144,725.42
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-13,089,651.01	128,961,073.61
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-13,089,651.01	128,961,073.61
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	463,909,966		181,903,211.1	282,006,754.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
3	Залруулсан үлдэгдэл				
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)			-13,089,651.01	-13,089,651.01
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	463,909,966		-194,992,862.14	268,917,103.9
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	692,404,000			692,404,000
11	Залруулсан үлдэгдэл				
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			128,961,073.61	128,961,073.6
13	Бусад дэлгэрэнгүй орлого				
14	Өмчид гарсан өөрчлөлт		181,724,011.3		181,724,011.3
15	Зарласан ногдол ашиг				
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,156,313,966	181,724,011.3	-66,031,788.53	1,272,006,188.7

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	338,476,880.00	357,262,174.37
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	331,565,680.00	356,994,761.04
1.1.6	Бусад мөнгөн орлого	6,911,200.00	267,413.33
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	298,481,874.27	310,814,523.65
1.2.1	Ажиллагчдад төлсөн	107,974,057.49	110,521,807.88
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,761,263.33	3,036,152.42
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	50,689,235.50	61,870,534.21
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	5,099,977.00	544,000.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	74,440,049.99	48,475,310.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	16,712,028.96	63,721,220.14
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	268,454.00	268,454.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	40,536,808.00	22,377,045.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	39,995,005.73	46,447,650.72
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	4,000,000.00	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	243,423.23	121,645.45
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,500,000.00	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,500,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	743,423.23	121,645.45
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	35,000,000.00	41,000,000.00
3.2.5	Бусад	35,000,000.00	41,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-35,000,000.00	-41,000,000.00
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	5,738,428.96	5,569,296.17
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,239,994.43	10,978,423.39
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,978,423.39	16,547,719.56

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа "Шохой тоосго нэгдэл" ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2019.03.15			САГ-2019/8/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа "Шохой тоосго нэгдэл" ТӨААТҮГ		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2018.12.25-ны өдрийн 03/5200 тоот ШШГЕГ-аас 70,740 мянган төгрөгийн үнэтэй Улаанбаатар хотод байрлах 3 өрөө байрыг Л.Батцэнгэлд өгч уг байрыг УТЗ данс, Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дансад бичсэн	70.7	Албан шаардлага	Захирал Ахлах нягтлан бодогч	Б.Баттулга Б.Азжаргал
2	Бараа материалын зардлаас байгууллагын өглөг хаасан	1.7	Зөвлөмж өгөх	Ахлах нягтлан бодогч	Б.Азжаргал
	ДҮН	72.4			